СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2022/240-НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.selenge@audit.gov.mn<br><br>Сүхбаатар сум<br>2022 он | Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br>Утас:7036-3040 Цахим хаяг:<br>Enkhtuyach@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Батмөнх<br>Утас: 7036-3036 Цахим хаяг:<br>Batmunkhb@audit.gov.mn<br>Аудитор: Ж.Цогт<br>Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ........ 3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5
    2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан........ 5-6
    2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан........ 7-8
    2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........ 9-10
    2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан........ 11
    2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан........ 12
    2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........ 13
3. Аудитын тайлан........ 14
    3.1 Ерөнхий зүйл ........ 14
    3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 14
    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 15
    3.4 Материаллаг байдал ........ 15
    3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 16
    3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........ 17
    3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 17
    3.8 Аудитын гол асуудал ........ 18
    3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... 18
    3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 19
    3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........ 19
4. Аудитын илрүүлэлт ........ 19-21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 22

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХТ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ЦЕГ | Цагдаагийн Ерөнхий газар |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.21 № СЭА-2022/240-НА-СТА-ТШЗ

танай ________________-ны № ________________-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Х.АЛТАНХУЯГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



018020047

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **83,851,811.95** | **69,486,026.61** |
| **33** | **АВЛАГА** | - | 3,700,442.00 |
| **335** | **Бусад авлага** | - | 3,700,442.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 3,700,442.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 83,851,811.95 | 65,785,584.61 |
| **351** | **Түүхий эд материал** | 42,866,992.95 | 39,126,068.61 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 41,911,803.95 | 38,581,869.61 |
| 35130 | Эм боох материал | 955,189.00 | 544,199.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 37,733,101.00 | 22,912,765.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,598,920.00 | 5,912,050.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,024,493.00 | 15,651,132.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,030,119.00 | 505,587.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,662,500.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 85,285.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,331,784.00 | 843,996.00 |
| 35600 | Мал амьтад | 3,251,718.00 | 3,746,751.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **422,659,035.19** | **504,480,407.98** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 422,659,035.19 | 504,480,407.98 |
| **392** | **Биет хөрөнгө** | 403,041,268.19 | 485,066,754.38 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 305,406,450.00 | 433,406,450.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (14,241,540.32) | (22,649,377.04) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 96,634,585.04 | 82,244,035.04 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (59,954,853.20) | (64,334,142.36) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 84,657,430.75 | 91,260,867.43 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (21,405,968.96) | (43,557,248.49) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24,232,177.00 | 24,232,177.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,287,012.12) | (15,536,007.20) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 19,617,767.00 | 19,413,653.60 |
| 39301 | Программ хангамж | 1,020,567.00 | 1,020,567.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (204,113.40) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,597,200.00 | 18,597,200.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **506,510,847.14** | **573,966,434.59** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **713,197.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 713,197.00 |
| **413** | **Өглөг** | - | 713,197.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 711,397.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 1,800.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 1,800.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **506,510,847.14** | **573,253,237.59** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 506,510,847.14 | 573,253,237.59 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 313,667,225.00 | 313,667,225.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 313,667,225.00 | 313,667,225.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 51,751,346.94 | 118,493,737.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 51,751,346.94 | 51,751,346.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 66,742,390.45 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 141,092,275.20 | 141,092,275.20 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **506,510,847.14** | **573,966,434.59** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **985,245,753.55** | **1,135,771,362.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **77,770,953.55** | **152,525,362.60** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 77,770,953.55 | 152,525,362.60 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 48,404,253.00 | 133,896,040.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,289,150.00 | 4,660,300.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 45,115,103.00 | 129,235,740.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **907,474,800.00** | **983,246,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 905,474,800.00 | 981,246,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 905,474,800.00 | 981,246,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **981,185,153.21** | **1,064,028,972.19** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **981,185,153.21** | **1,064,028,972.19** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 974,967,385.21 | 1,060,582,526.59 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 751,080,718.00 | 816,980,876.00 |
| 210101 | Үндсэн цалин | 485,654,442.00 | 524,156,805.00 |
| 210102 | Нэмэгдэл | 265,426,276.00 | 289,474,071.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 3,350,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,883,796.00 | 18,515,689.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,422,290.00 | 1,657,137.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 167,328.00 | 184,495.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 133,663.00 | 36,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 33,466.00 | 147,594.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,127,049.00 | 16,489,563.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 55,482,051.00 | 65,054,451.47 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,449,595.00 | 20,592,488.47 |
| 210302 | Түлш, халаалт | 34,902,600.00 | 40,589,563.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,129,856.00 | 3,872,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,303,822.00 | 65,833,693.74 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,190,230.00 | 8,243,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,717,123.00 | 30,587,032.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,749,100.00 | 3,075,132.40 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 120,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,300.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,407,069.00 | 3,991,266.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 19,696,413.34 |
| **2105** | **Нормативт зардал** | 12,294,145.00 | 11,183,468.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,294,145.00 | 11,183,468.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,235,950.00 | 21,356,562.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,900,850.00 | 4,148,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 13,335,100.00 | 17,208,362.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,113,000.00 | 2,941,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,113,000.00 | 2,941,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 524,668.00 | 3,522,598.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 3,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 333,492.00 | 290,350.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 165,000.00 | 165,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 26,176.00 | 67,248.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 82,049,235.21 | 55,194,188.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 540,000.00 | 319,648.53 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 837,475.92 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 81,509,235.21 | 54,037,063.93 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,217,768.00 | 3,446,445.60 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,560,000.00 | 1,660,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 300,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,260,000.00 | 1,360,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,657,768.00 | 1,786,445.60 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,657,768.00 | 1,786,445.60 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **4,060,600.34** | **71,742,390.41** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 4,999,999.96 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 4,999,999.96 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (4,999,999.96) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **4,060,600.34** | **66,742,390.45** |

4317143998
МЮАО...

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **910,763,950.00** | **987,906,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,289,150.00** | **4,660,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,289,150.00 | 4,660,300.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,289,150.00 | 4,660,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,289,150.00 | 4,660,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **907,474,800.00** | **983,246,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 905,474,800.00 | 981,246,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 905,474,800.00 | 981,246,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **908,274,550.00** | **987,781,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **908,274,550.00** | **987,781,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **902,056,782.00** | **984,334,854.40** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 751,978,643.00 | 820,208,820.00 |
| 210101 | Үндсэн цалин | 494,883,155.00 | 471,076,220.00 |
| 210102 | Нэмэгдэл | 257,095,488.00 | 349,132,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,883,796.00 | 18,274,990.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,883,796.00 | 18,274,990.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 55,482,051.00 | 65,114,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,449,595.00 | 20,652,437.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,902,600.00 | 40,589,563.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,129,856.00 | 3,872,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,832,700.00 | 40,487,132.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,102,000.00 | 8,102,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,770,400.00 | 26,770,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,420,000.00 | 3,075,132.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 120,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,300.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,300,000.00 | 2,300,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 12,262,500.00 | 12,400,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 165,500.00 | 300,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,100,000.00 | 11,100,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 997,000.00 | 1,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,305,600.00 | 18,873,362.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 308,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,000,000.00 | 2,875,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,997,600.00 | 15,998,362.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,113,000.00 | 2,941,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,113,000.00 | 2,941,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 498,492.00 | 3,455,350.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 3,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 333,492.00 | 290,350.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 165,000.00 | 165,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,700,000.00 | 2,579,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,700,000.00 | 579,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,217,768.00** | **3,446,445.60** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,560,000.00 | 1,660,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 300,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,260,000.00 | 1,360,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,657,768.00 | 1,786,445.60 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,657,768.00 | 1,786,445.60 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ 3=2-1** | **2,489,400.00** | **125,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,489,400.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,489,400.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,489,400.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,489,400.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-2,489,400.00** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 125,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 313,667,225.0 | 141,092,275.2 | 47,690,746.6 | 502,450,246.8 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **313,667,225.0** | **141,092,275.2** | **47,690,746.6** | 502,450,246.8 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 4,060,600.3 | 4,060,600.3 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **313,667,225.0** | **141,092,275.2** | **51,751,346.9** | 506,510,847.1 |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **313,667,225.00** | **141,092,275.2** | **51,751,346.9** | 506,510,847.1 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **313,667,225.0** | **141,092,275.2** | **51,751,346.9** | 506,510,847.1 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 66,742,390.4 | 66,742,390.4 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **313,667,225.0** | **141,092,275.2** | **118,493,737.4** | **573,253,237.6** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 984,246,000.00 | 984,119,854.40 | 126,145.60 | 0.01 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 984,246,000.00 | 984,119,854.40 | 126,145.60 | 0.01 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 982,586,000.00 | 982,459,854.40 | 126,145.60 | 0.01 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 820,414,300.00 | 820,384,820.00 | 29,480.00 | 0.00 |
| 210101 | Үндсэн цалин | 471,281,700.00 | 471,252,220.00 | 29,480.00 | 0.01 |
| 210102 | Нэмэгдэл | 349,132,600.00 | 349,132,600.00 | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 18,313,900.00 | 18,274,990.00 | 38,910.00 | 0.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,313,900.00 | 18,274,990.00 | 38,910.00 | 0.21 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,124,400.00 | 65,114,400.00 | 10,000.00 | 0.02 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 23,671,400.00 | 20,652,437.00 | 3,018,963.00 | 12.75 |
| 210302 | Түлш, халаалт | 37,580,600.00 | 40,589,563.00 | (3,008,963.00) | (8.01) |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,872,400.00 | 3,872,400.00 | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,532,400.00 | 40,487,132.40 | 45,267.60 | 0.11 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,102,000.00 | 8,102,000.00 | - | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,770,400.00 | 26,770,000.00 | 400.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,120,000.00 | 3,075,132.40 | 44,867.60 | 1.44 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | 120,000.00 | - | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 | - | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,300,000.00 | 2,300,000.00 | - | - |
| **2105** | **Нормативт зардал** | 12,400,000.00 | 12,400,000.00 | - | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 300,000.00 | 300,000.00 | - | - |
| 210502 | Хоол, хүнс | 11,100,000.00 | 11,100,000.00 | - | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19,000,000.00 | 18,998,362.00 | 1,638.00 | 0.01 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | - |
| 210604 | Урсгал засвар | 16,000,000.00 | 15,998,362.00 | 1,638.00 | 0.01 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,765,000.00 | 2,765,000.00 | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,765,000.00 | 2,765,000.00 | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,456,000.00 | 3,455,350.00 | 650.00 | 0.02 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 291,000.00 | 290,350.00 | 650.00 | 0.22 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 165,000.00 | 165,000.00 | - | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 580000.00 | 579800.00 | 200.00 | 0.03 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 580,000.00 | 579,800.00 | 200.00 | 0.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1660000.00 | 1660000.00 | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,660,000.00 | 1,660,000.00 | - | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 300,000.00 | 300,000.00 | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,360,000.00 | 1,360,000.00 | - | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 984,246,000.00 | 984,119,854.40 | 126,145.60 | 0.01 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 981,246,000.00 | 979,459,554.40 | 1,786,445.60 | 0.18 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 981,246,000.00 | 979,459,554.40 | 1,786,445.60 | 0.18 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 3,000,000.00 | 4,660,300.00 | (1,660,300.00) | (55.34) |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,000,000.00 | 4,660,300.00 | (1,660,300.00) | (55.34) |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 56.00 | 56.00 | - | - |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | - | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 53.00 | 53.00 | - | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,000,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,000,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн */Цаашид Сайхан сум дахь Цагдаагийн хэлтэс гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цалин хөлсний бүртгэл, өр төлбөр үүсгэхгүй байх, төлбөрийн цахим баримт, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сум дахь Цагдаагийн хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 42/3-91 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Сайхан сум дахь Цагдаагийн хэлтсийн эрхэм зорилго нь *“Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах зорилт дэвшүүлж ажиллах”*-д оршино.

Сайхан сум дахь Цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх;
- Нийгмийн хэв журам сахиулах;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Захиргааны хяналт тавих үүрэг гүйцэтгэх буюу хуулиар хүлээлгэсэн хуулийн биелэлтэд хяналт тавих.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ЦЕГ-аас 2013 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс болон шууд захирагчийн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сум дахь Цагдаагийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг *"дунд"* гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 981,185.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,811.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 6,868.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сайхан сум дахь Цагдаагийн хэлтсийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67,455.6 мянган төгрөгөөр буюу 13.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

4317143998
МЮА0065 9055436

*Хүснэгт 1:* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | 3,700.4 | 3,700.4 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 83,851.8 | 65,785.6 | (18,066.2) |
| Үндсэн хөрөнгө | 422,659.0 | 504,480.4 | 81,821.4 |
| **Нийт хөрөнгө** | 506,510.8 | 573,966.4 | 67,455.6 |
| Өр төлбөр | | 713.2 | 713.2 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 313,667.2 | 313,667.2 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 506,510.8 | 573,966.4 | 67,455.6 |

Авлагын данс 3,700.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь тус газрын нягтлан бодогчоор ажиллаж байсан П.Эрдэнэ-Очир нь албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг санаатайгаар нэмэгдүүлэн олгосноос шалтгаалсан бөгөөд уг асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 65,785.5 мянган төгрөг болж 18,066.2 мянган төгрөгөөр буурсан нь ЦЕГ-аас 5,795.9 мянган төгрөгийн хувцас, хамгаалах хэрэгсэл, сум, үнэт цаас, 1,607.6 мянган төгрөгийн төл малын орлого, Шунхлай петролиум ХХК-аас 400.0 мянган төгрөгийн шатахуун талоны урамшуулал зэрэг нийт 7,803.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан болон төсвийн хөрөнгөөр 59,622.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 85,491.8 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /*анхны өртгөөр*/ 650,761.3 мянган төгрөг болж өмнөх оноос 120,212.9 мянган төгрөгөөр өссөн нь ЦЕГ-аас 6,255.0 мянган төгрөгийн 2 тээврийн хэрэгсэл, 6,603.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж болон 2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 128,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Орхон сум, Номгон тосгоны Цагдаагийн хэсгийн байрыг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэсэн, 20,645.5 мянган төгрөгийн үнэ бүхий 3 тээврийн хэрэгслийг аймгийн ИТХТ-ийн тогтоолыг үндэслэн акталсантай холбоотой байна.

Өр төлбөрийн данс 713.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь албан хаагчдад олгосон хоолны хөнгөлөлтөөс НДШ болон ХХОАТ-ыг суутгаагүйгээс голлон шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,135,771.4 өмнөх оноос 150,525.6 мянган төгрөгөөр буюу 15.3 хувиар өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 140,858.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,064,029.0 мянган төгрөг болж өмнөх оноос 82,843.8 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөнөөс голлон шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг тус бүр 984,246.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг өөрчлөлт оруулалгүйгээр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 984,246.0 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 984,246.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 984,119.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 99.9 хувьтай тайлагнагдсан бөгөөд тайлант оны эцэст үндсэн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 126.2 мянган төгрөг болон үндсэн үйл ажиллагааны орлого 1,660.3 мянган төгрөг зэрэг нийт 1,786.5 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газраас 2,000.0 мянган төгрөгийн хар тамхины ургамал устгал арга хэмжээний зардал хуваарилагдан ирж зориулалтын дагуу зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1. ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 6/1865 дугаар албан бичгээр төсвийн хэмнэлтийг ЦЕГ-ын ахмадын санд төвлөрүүлэх чиглэлийн дагуу тухайн жилийн төсөвт тусгагдаагүй 319.6 мянган төгрөгийг тус дансанд шилжүүлсэн байгаа нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “*Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг **төсөвтөө жил бүр тусгана**”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж, батлуулсны үндсэн дээр шилжүүлж байх шаардлагатай.

3.7.2 Тус хэлтсийн нягтлан бодогчоор ажиллаж байсан П.Эрдэнэ-Очир нь албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг санаатайгаар нэмэгдүүлэн олгосноос шалтгаалан 3,700.4 мянган төгрөгийн авлага үүссэн бөгөөд уг асуудлыг хууль, хяналтын байгууллагаас шалгаж байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сайхан сум дахь Цагдаагийн хэлтэс нь мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс дараах 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- *Дараа жилийн төсвийн төсөл,*
- *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт,*
- *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт,*
- *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ,*

- *Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл,*
- *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг,*
- *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл,*
- *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр,*
- *Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт,*
- *Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн*

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөвлөмж өгөгдсөнийг биелүүлээгүй байна.

*Хүснэгт 2.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Зөвлөмж | 1 | - | - | - | - |
| **Нийт дүн** | **1** | **-** | **-** | **-** | **-** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1. ЦЕГ-аас 2021 оны 12 сард балансаас балансад шилжиж ирсэн 6,255.0 мянган төгрөгийн 2 суудлын автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь байгууллагын эзэмшилд бүртгэгдээгүй байгаа нь Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 3.2-д “Өмчлөгч нь энэ журмын 3.1-д заасан шилжилт, хөдөлгөөнийг 7 хоногийн дотор хийлгэх үүрэгтэй”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (а)-д тодорхойлсон заалттай нийцээгүй ба “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд 2022 оны 2-р улиралд багтаан тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагын эзэмшилд шилжүүлэн авах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 22,605.7 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал:***

*1.1. Илрүүлэлт:* Авлага, өр төлбөр, төлбөрийн тооцоог хянан баталгаажуулаагүйн улмаас албан хаагчдын хоолны хөнгөлөлтөөс холбогдох суутгалыг хийлгүйгээр НДШ-ийн 481.4 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 231.8 мянган төгрөгийн зэрэг нийт 713.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:* Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж, гүйцэтгэж байх.

***2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал:***

*2.1.1 Илрүүлэлт:* Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ЦЕГ-аас 2013 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

*2.1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “*Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”* гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн тул Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль эрхийн актын өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллах .

*2.2.1 Илрүүлэлт:* Ажлын үр дүнгээр сахилгын шийтгэл оногдуулж, давхардсан тоогоор 75 алба хаагчийн цалин хөлсийг 8,257.6 мянган төгрөгөөр бууруулахдаа цалингийн цэсийн нэмэгдэл талд хасах утгаар оруулж, цалингийн тооцоолсон өглөгийг бууруулан, цалингийн зардлыг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

*2.2.2 Өгсөн зөвлөмж:* Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын ажиллагчидтай холбогдсон зардлын бүртгэлийн 3.6 дахь”*Тайлангийн хугацааны цалингийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ, 3.6.(б) дэх “Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн*

*бүртгэнэ. Дт.өглөг-Цалингийн тооцооны Кт.Бусад өглөг-ажиллагчийн төлөх бусад суутган төлбөр*" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид цалингийн тооцооллыг зөв хийж, бүртгэлийг стандартын дагуу гүйцэтгэх.

***3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:***

*3.1 <u>Илрүүлэлт:</u>* Шилэн дансанд мэдээлбэл зохих 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*3.2 <u>Өгсөн зөвлөмж</u>:* Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

***4. Анхан шатны болон цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал:***

*4.1 <u>Илрүүлэлт:</u>* Тайлант онд 13,634.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

*4.2 <u>Өгсөн зөвлөмж</u>:* Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь "*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй"* гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д* заасан *"загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтэс | 5 | 22,605.7 | - | - | - | - | - | - | 5 | 22,605.7 |